

ТАНИЛЦУУЛГА

“Дүрэм шинэчлэн батлах тухай”
Засгийн газрын тогтоолын төслийн
талаар

Монгол Улсын анхны Замын хөдөлгөөний дүрэм 1925 оны 5-р сарын 22-ны өдөр Ардын Засгийн газрын 18-р хурлаар “Аливаа гал усны уурын хүчээр явах тэрэг зэргийг БНМАУ-ын хязгаарын дотор хэрхэн хэрэглэхийн түр дүрэм” нэртэй батлагдсанаас хойш 1930, 1936, 1940, 1950, 1957, 1960, 1966, 1985, 1991, 1996, 2004 онуудад буюу нийтдээ 11 удаа шинэчлэгдэж, 1976, 1987, 1993, 1998, 2003 онуудад нэмэлт өөрчлөлт орж, тухайн үеийн нийгэм, эдийн засаг, автотээврийн салбарын хөгжил, замын хөдөлгөөний зохион байгуулалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн шинэчлэл, олон улсын жишигт нийцэн боловсронгуй болон хөгжиж ирсэн түүхтэй.

Засгийн газрын 2004 оны 4-р сарын 5-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдаж өнөөдрийг хүртэл мөрдөгдөж байгаа “Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм”-ийг шинэчлэн найруулах шаардлага дараах хэд хэдэн үндэслэлээр бий болж байна. Үүнд:

1. Монгол Улсын нэгдэн орсон “Замын хөдөлгөөний тухай” болон “Замын дохио, тэмдгийн тухай” Венийн конвенцуудад орсон нэмэлт өөрчлөлтүүд нь 2006 оны 3-р сарын 28-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон бөгөөд тус конвенцийн 43-р зүйлд тусгагдсан шилжилтийн заалтын дагуу хүчин төгөлдөр болсноос хойш 5-н жилийн дараагаас буюу 2011 оны 3-р сарын 29-ний өдрөөс эхлэн гишүүн орнуудад хэрэглэгдэж эхэлсэн болно. Иймд тус конвенцуудын нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх үүднээс Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд зохих өөрчлөлт оруулах шаардлагатай;

2. Улсын Их Хурлаас 2015 оны 7-р сарын 8-ны өдөр “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулийг шинэчлэн баталсан бөгөөд 2015 оны 9-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Уг хуульд нийцүүлэн Замын хөдөлгөөний дүрмийг шинэчлэн найруулах шаардлага бий болсон;

3. Монгол Улсын Стандартчиллын Үндэсний зөвлөлөөс замын хөдөлгөөн зохион байгуулах техник хэрэгслүүд болон тэдгээрийн хэрэглээг олон улсын нийтлэг жишигт бүрэн нийцүүлэх зорилгоор 2014 оны 4-р сарын 25-ны өдрийн 12-р тогтоолоор “Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4597:2014, “Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4759:2014, “Авто замын гэрлэн дохио. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4980:2014, “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” MNS 4596:2014 стандартуудыг шинэчлэн баталж, мөрдөж байна. Эдгээр стандартад орсон өөрчлөлтийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 4.3-д заасны дагуу Замын хөдөлгөөний дүрэмд тусгах шаардлагатай байна;

4. Улсын хэмжээнд автотээврийн хэрэгслийн тоо жилээс жилд нэмэгдэж, нийслэлийн замын ачаалал, хөдөлгөөний нягтрал ихэссэнтэй холбогдон үүсэн бий болоод байгаа авто замын түгжрэлийг сааруулах, хөдөлгөөний эрчмийг сайжруулах, автомашинаас үүдсэн агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн тодорхой заалтуудыг Замын хөдөлгөөний дүрэмд тусгаж тулгамдсан асуудлуудыг

шийдвэрлэхэд нөлөөлөхүйц эрх зүйн зохицуулалтыг бий болгох зайлшгүй шаардлагатай байна;

5. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2010 онд 64/255 дугаар тогтоол батлан 2011-2020 оныг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын жил” болгон зарласан, мөн Монгол Улсын Засгийн газраас 2012 онд 146 дугаар тогтоолоор “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги”, төлөвлөгөөг батлан 2020 он гэхэд зам тээврийн ослын улмаас гэмтсэн болон нас барсан хүний тоог тус бүр 50 хувиар бууруулах зорилт дэвшүүлсэн бөгөөд энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд Замын хөдөлгөөний дүрмийг шинэчлэх шаардлага тулгарч байна.

Замын хөдөлгөөний дүрмийг шинэчилсэнээр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, хэргийг бууруулах, хөдөлгөөнд оролцогчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, замын түгжрэл, агаарын бохирдлыг багасгах, зам тээврийн хэрэг, зөрчлүүдийг шийдвэрлэхэд тодорхой үр нөлөө үзүүлэх ач холбогдолтой гэж үзлээ.

Дээр дурдсан шаардлагууд болон замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой олон улсын гэрээ, конвенц, гадаадын олон улс орны хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүд ба өөрийн орны зам тээврийн ослын судалгаан дээр тулгуурлан Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг 27 бүлэг, 224 зүйл, 4 хавсралттайгаар боловсруулсан болно.

Дүрэмд оруулсан зарим онцлог нэмэлт, өөрчлөлт түүний ач холбогдлын тухай

1. Зам тээврийн осол, хэргийг бууруулахад чиглэсэн нэмэлт, өөрчлөлтүүд:

а/ Жолоочийн анхаарал, болгоомжгүй байдлаас шалтгаалсан зам тээврийн осол сүүлийн үед нэмэгдэж байгааг харгалзан:

- тусгай дуут болон гэрэл дохио ажиллуулсан тээврийн хэрэгслийн жолооч нь бусад жолоочоос давуу эрхтэй байх боловч анхаарал, болгоомжоо сулруулахгүй байх үүднээс бусад хөдөлгөөнд оролцогч өөрт нь зам тавьж өгч байгааг бүрэн мэдсэний үндсэн дээр давуу эрх эдлэхийг төсөлд нэмж тусгалаа;
- харанхуй үед болон үзэгдэлт хангалтгүй нөхцөлд жолооч хэдийгээр тухайн зам дээрх хурдны зөвшөөрөгдөх дээд хэмжээг хэтрүүлээгүй ч тээврийн хэрэгслийнхээ хол, ойрын гэрлийн гэрэлтүүлэх хүрээ, замын гэрэлтүүлгийн байдал зэргээс хамааруулан хурдаа тохируулж яваагүйгээс зам тээврийн осол байнга гарч байгааг таслан зогсоох зорилгоор харанхуй үед болон үзэгдэлт хангалтгүй нөхцөлд өөрийн үзэгдэх хүрээн дотор тээврийн хэрэгслээ зогсоох боломжтой хурдыг сонгож явахыг жолоочид үүрэг болголоо;
- хөдөлгөөнд оролцогчдын анхаарлыг дээшлүүлж, зам тээврийн ослоос сэргийлэх үүднээс Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцийн 32-р зүйлийн 6-д "Өдрийн цагт замаар яваа аливаа мотоцикл урд талдаа дор хаяж нэг ойрын гэрэл, ард талдаа улаан өнгийн гэрэл асааж явна" гэж заасны дагуу төсөлд өдрийн цагаар мотоцикл, мопед жолоодож яваа үедээ ойрын гэрлээ асааж явах тухай заалт тусгасан болно. Энэ журмыг гадаадын олон улс орон мөрддөг.

б/ Тээврийн хэрэгслийн хурдаас шалтгаалсан зам тээврийн ослыг бууруулах үүднээс:

- мотоцикл, чиргүүлтэй автомашинаар суурин газрын гадна цагт 60 км-ээс илүү хурдтай явахыг хориглосон бөгөөд энэ нь хөдөө, орон нутгийн замд ихээр гарч буй мотоциклын ослыг бууруулахад нөлөө үзүүлнэ гэж үзлээ;
- замын зэргэлдээх нутаг дэвсгэр, ялангуяа явган хүний хөдөлгөөн ихтэй үзвэр, худалдаа үйлчилгээний талбай зэрэг газруудад тээврийн хэрэгслээр хурдтай явснаас шалтгаалж осол, эндэгдэл гардаг явдлыг зогсоох үүднээс замын зэргэлдээх нутаг дэвсгэр дотор цагт 20 км-ээс илүү хурдтай явахыг хориглосон заалт тусгалаа;
- “хүнд буюу овор ихтэй, мөн аюултай ачаа тээвэрлэж яваа үед холбогдох журам, стандарт, техникийн баримт бичгээр тогтоосон дээд хурдыг хэтрүүлэх”-ийг хориглосон заалт оруулснаар онцгой ачаатай тээврийн хэрэгслийн хурдыг тухайн ачааны онцлогт тохируулан тусгайлан тогтоох, ингэснээр хурдаас шалтгаалсан осол гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд ач холбогдолтой юм.

в/ Хөдөө орон нутагт, харанхуй үед малчид мал сүргийг замын дагуу буюу зам хөндлөн тууж гаргахдаа замын хөдөлгөөний аюулгүй байдлыг алдагдуулж, зам тээврийн осол гаргах тохиолдол удаа дараа гарах болсонтой холбогдуулан “Харанхуй үед замын гэрэлтүүлэггүй хэсэгт болон үзэгдэлт хангалтгүй нөхцөлд малыг замын дагуу тууж явахыг хориглоно. Харин зам хөндлөн тууж гаргах зайлшгүй тохиолдолд замын дагуу хоёр тийш тээврийн хэрэгсэл ирэх зүгт гэрэл (дэнлүү) буюу гэрэл ойлгуур барьсан хүн хашиж гаргана” гэсэн заалт нэмж тусгалаа;

г/ Зам дээр ажил, үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүсийг, ялангуяа замын цагдаа, зохицуулагчийг тээврийн хэрэгслээр дайрах, мөргөх, шүргэх зэрэг осол, хэрэг цөөнгүй гарч байгааг харгалзан, тэдгээр хүмүүсийн аюулгүй байдлыг хамгаалах үүднээс “зам дээр ажил, үүрэг гүйцэтгэж байгаа хүний дэргэдүүр өнгөрөхдөө хурдаа хасаж, түүнд аюул, осолтой байдал үүсгэхгүйгээр зорчих”-ыг жолоочид үүрэг болгосон болно.

2. Жолоочийн амь насыг хамгаалахад чиглэсэн нэмэлт, өөрчлөлтүүд:

а/ Хамгаалах малгай өмсөхийг зөвхөн мотоциклын жолоочид үүрэг болгодог байсныг Замын хөдөлгөөний тухай Венийн конвенц (1-р хавсралтын 5), мөн тус конвенцийн нэмэлт болох Европын хэлэлцээр (хавсралтын 20-р зүйл)-ыг үндэслэн мопедын жолоочид мөн хамааруулахаар тусгалаа;

б/ “Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд ноцтой хохирол учирсан байж болзошгүй зам тээврийн ослын тохиолдол харсан даруйд очиж тусламж үзүүлэх, цагдаагийн байгууллагад яаралтай мэдэгдэх”, “зам тээврийн осол, байгалийн гамшиг болон бусад аюул, эрсдэлд өртөж болзошгүй нь илэрхий байдалтай саатаж зогссон (зайлшгүй зогсолт хийсэн) жолоочийн дохиогоор зогсож, бололцоотой тусламж үзүүлэх” гэсэн заалтыг нийт жолоочид үүрэг болгохоор тусгалаа. Энэ нь зам тээврийн осол, байгалийн гамшиг зэрэгт өртөж болзошгүй жолоочийн амь насыг хамгаалахад ач холбогдолтой юм.

3. Явган зорчигчийн амь насыг хамгаалахад чиглэсэн нэмэлт, өөрчлөлтүүд:

а/ Явган зорчигч харанхуй үед зам тээврийн осолд өртөх явдлыг бууруулах үүднээс “Харанхуй үед гэрэлтүүлэггүй замд болон үзэгдэлт хангалтгүй нөхцөлд зорчих хэсгийн зах буюу хөвөөгөөр явах тохиолдолд явган зорчигч нь жолоочид харагдах нөхцөлөө сайжруулах үүднээс аль болох тод гэгээлэг өнгийн, боломжтой бол гэрэл ойлгох шинж чанар бүхий хувцас хэрэглэл, эд зүйлстэй явбал зохино”

гэсэн зөвлөмжийн чанартай заалтыг нэмж тусгасан бөгөөд энэ шаардлагыг гадаадын олон улс орон, ялангуяа европын ихэнх орон замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлж байна;

б/ Явган зорчигч нь “зорчих хэсгээр явж байхдаа утсаар ярих, гар утас болон түүнтэй ижил төстэй тоглоом, хэрэгсэл оролдож ширтэх, зохицуулагчийн шүглийн чимээ, бусдын дуут дохио, анхааруулгыг сонсох боломжийг хязгаарласан чихэвч зүүх, ном, сонин гэх мэт зүйл унших”, “зорчих хэсэг дээр дугуйт тэшүүр, дугуйт хавтан болон түүнтэй ижил төстэй, биеийн тамир, спорт, тоглоомын зориулалттай хэрэгслээр явах”-ыг тус тус хориглосон заалтуудыг нэмж тусгасан бөгөөд ялангуяа сүүлийн үед хүүхэд залуучууд зам хөндлөн гарч байхдаа чихэвч зүүх, гар утас мэтийн эд зүйлсэд анхаарлаа сарниулах зэргээр болгоомж сэрэмж алдсанаас осолд өртөх тохиолдол ихсэх хандлагатай байгааг харгалзан дээрх заалтуудыг дүрэмд тусгасан болно;

в/ Тэмдгээр тусгайлан тэмдэглэсэн хорооллын доторх зорчих хэсэг дээр явган зорчигчийн давуу эрх, аюулгүй байдлыг хамгаалах үүднээс хороолол дотор гүйцэж түрүүлэх үйлдэл хийхийг жолоочид хориглосноос гадна, хорооллын доторх зорчих хэсгийг дамжин өнгөрөх зорилгоор ашиглахыг жолоочид хориглосон заалт тусгасан болно;

г/ Одоогийн мөрдөж буй дүрмийн 12.5-д "... тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө" гэснийг төсөлд "... хөдөлгөөнд оролцогчдод зам тавьж өгнө" гэж өөрчилснөөр зохицуулдаг уулзвар дээр улаан буюу шар гэрэлтэй хамт ассан нэмэгдэл гэрэл дохиогоор явж буй жолооч бусад чиглэлээс яваа тээврийн хэрэгслийн жолоочоос гадна мөн зам хөндлөн гарч яваа явган зорчигчид зам тавьж өгөхийг тодорхой болгосон бөгөөд энэ нь нэмэгдэл гэрэл дохиогоор баруун буюу зүүн гар тийш эргэхдээ явган зорчигчид аюул саад учруулахгүй байх нөхцөлийг хангах чухал өөрчлөлт болно;

д/ Одоогийн мөрдөж буй дүрмийн 13.1-д зааснаар жолооч явган хүний гарцаар гарч байгаа хүнд зам тавьж өгөх үүрэгтэй байдаг бол төсөлд явган хүний гарцаар гарч байгаагаас гадна мөн гарахаар завдаж байгаа явган зорчигчид зогсож зам тавьж өгөх үүрэг хүлээхээр тусгасан нь явган зорчигчийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтойгоос гадна хөдөлгөөнд оролцогчид нэг нэгэндээ хүндэтгэлтэй хандах соёлыг төлөвшүүлэхэд үр нөлөөтэй заалт болно. Ийм зохицуулалт гадаадын олон оронд мөрдөгддөг.

4. Хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс хамгаалахад чиглэсэн нэмэлт, өөрчлөлтүүд:

а/ Ерөнхий боловсролын сургуулийн ойролцоох замын хэсэгт хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс “Сургууль орчмын бүс” зохицуулалтыг MNS 4596, MNS 4597 стандартуудын дагуу төсөлд тусгасан;

б/ Замын хөдөлгөөнд жагсаалаар оролцох хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах үүднээс хэрэв жагсаалаар яваа хүүхдийн тоо дөчөөс олон бол жагсаалын зөвхөн урд болон ардаас гадна дунд хэсэгт нь насанд хүрсэн хүн хамгаалж явах тухай нэмэлт орууллаа;

в/ Хүүхдийг зохион байгуулалттай тээвэрлэхэд хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах үүднээс дүрэмд хэд, хэдэн нэмэлт өөрчлөлт оруулахаар төсөлд тусгасан болно. Тухайлбал:

- хүүхдийг зохион байгуулалттай тээвэрлэхэд зөвхөн автобус ашиглаж байхаар шинэчлэн найруулсан болно. Мөн байнгын гэрээний дагуу сургуулийн хүүхэд тээвэрлэх автобус нь 2014 онд шинээр батлагдсан MNS 6440 стандартын шаардлагыг хангасан байхаар нэмж тусгалаа;

- «Хүүхэд тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл» таних тэмдэг бүхий автобусаас хүүхэд буулгах, түүнд суулгах үедээ ослын дохионы гэрлээ асааж байх, «Хүүхэд тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл» таних тэмдэг бүхий автобус ослын дохионы гэрлээ асааж зогссон байвал ойртон ирсэн жолооч хурдаа хасаж анхаарал болгоомжтой явах, хүүхдүүд зам хөндлөн гарч байвал зогсож урьдчилан өнгөрүүлэх тухай заалтууд тусгалаа;
- зам тээврийн ослын үед хүүхдүүдийг бэртэл, гэмтлээс хамгаалах үүднээс хүүхэд тээвэрлэх автобусан доторх суудал бүрийг хамгаалах бүсээр тоногловсон байх шаардлагыг нэмж тусгалаа.

г/ «Хүүхэд» тэмдгээр анхааруулсан замын хэсэгт гүйцэх үйлдэл хийхдээ гүйцэгдэж байгаа тээврийн хэрэгслийн урдуур хүүхэд явж байгаа эсэхийг анхаарч мэдсэн байхыг жолоочид үүрэг болголоо;

д/ Жолооч нь тээврийн хэрэгслээ орхиж явахдаа 7 нас хүрээгүй хүүхдийг насанд хүрсэн харгалзах хүнгүйгээр тээврийн хэрэгсэлд үлдээхийг хоригловсон заалт тусгалаа;

е/ Бусад улсын хууль тогтоомжийг судлан дүрмийн “Суудлын автомашинд болон ачааны автомашины жолоочийн бүхээгт 10 хүртэлх насны хүүхдийг тээвэрлэхдээ биеийн жин, өсөлтөд нь тохирсон зориулалтын нэмэгдэл суудал буюу хамгаалах хэрэгсэл ашиглана” гэж шинээр нэмж тусгалаа.

5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд замын хөдөлгөөнд аюул, бэрхшээлгүй оролцох нөхцөлийг хангахад чиглэсэн нэмэлт, өөрчлөлтүүд:

а/ Харааны бэрхшээлтэй хүн зорчих хэсгээр хөндлөн гарахдаа цагаан таяг барьсан байх, хэрэв зорчих баримжаа алдаж, явган хүний гарцын байршлыг тогтоож чадахгүй болсон буюу гэрлэн дохионы заалтыг мэдэх боломжгүй бол бусдаас туслалцаа авах, ийм бололцоогүй тохиолдолд таягаараа дохио өгч анхаарал болгоомжтой зам хөндлөн гарах талаар тодорхой заалт оруулсан бөгөөд мөн цагаан таяг нь харанхуй үед гэрэл ойлгодог буюу гэрэлтдэг гадаргуутай байх шаардлагыг тусгалаа;

б/ 2014 онд шинэчлэн баталсан замын гэрлэн дохионы MNS 4980 стандартын 2.7, 3.8, 3.9 заалтыг үндэслэн явган зорчигчийн гэрлэн дохио нь харааны бэрхшээлтэй хүмүүст явган хүний гарцын байршлыг мэдэгдэх буюу тухайн гэрлэн дохионы ажиллагааны горимыг мэдээлэхэд зориулсан нэмэгдэл дуут дохиотой байж болох талаар төсөлд тусгасан бөгөөд энэ нь харааны бэрхшээлтэй хүн замын хөдөлгөөнд аюул, бэрхшээлгүй оролцоход чухал ач холбогдолтой юм;

в/ Төсөлд заасан чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр бусад тээврийн хэрэгсэл байрлан явахыг хоригловсон заалтыг «Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн» таних тэмдэг бүхий тээврийн хэрэгсэлд хамаарахгүй байхаар тусгалаа;

г/ «Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн» таних тэмдэг бүхий тээврийн хэрэгсэл нь замын хориглох тэмдгүүдийн 2.2 «Хөдөлгөөн хориотой», 2.3 «Механикжсан тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хориотой», 2.28 «Удаан зогсох хориотой» тэмдгүүдийн үйлчлэлд хамаарахгүй байхаар тусгасан бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн замын хөдөлгөөнд оролцох нөхцөлийг хөнгөвчлөхөд чиглэсэн заалт болно гэж үзлээ;

д/ «Сонсголын бэрхшээлтэй жолооч»-ийн таних тэмдгийн дүрсийг “цэнхэр дэвсгэртэй дөрвөлжин дотор цагаан өнгөөр сонсголын бэрхшээлийг илэрхийлэх олон улсын дүрсэн тэмдэглэгээг зурна” гэж өөрчилсөн бөгөөд энэ өөрчлөлт нь тухайн таних тэмдэгтэй тээврийн хэрэгслийг бусад хөдөлгөөнд оролцогчид таньж мэдэхэд хялбар болох давуу талтай юм;

е/ Өөрийн үйлдлийг хянах чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй /сэтгэцийн өвчтэй/ хүнийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд явганаар оролцуулахгүй байхыг иргэн, хуулийн этгээдэд үүрэг болголоо.

6. Тээврийн хэрэгслээр зорчигчийн амь насыг хамгаалахад чиглэсэн нэмэлт, өөрчлөлтүүд:

а/ “Тээврийн хэрэгслээр зорчигч” нэр томъёоны тодорхойлолтод “Тээврийн хэрэгсэл рүү орж байгаа болон түүнээс бууж байгаа хүнийг мөн хамааруулж ойлгоно” гэсэн нэмэлт оруулж уг нэр томъёоны хамрах хүрээг өргөтгөлөө;

б/ Хамгаалах малгай өмсөөгүй зорчигч тээвэрлэхгүй байхыг мопедын жолоочид үүрэг болгосноос гадна, хамгаалах малгайг зааврын дагуу өмсөх үүргийг мопедын зорчигчид мөн хамааруулсан болно. Мөн мотоцикл, мопедын зорчигчийн хамгаалах малгай нь MNS 6629 стандартын шаардлагыг хангасан байх талаар заалаа;

в/ “Тээврийн хэрэгслээс зүүгдэх”, мөн “тээврийн хэрэгслийн явдал дунд буух, суух, ачаа ачих, буулгах” зэргийг тээврийн хэрэгслээр зорчигчид хориглосон заалт нэмж тусгалаа;

г/ Зогсож байгаа тээврийн хэрэгслээс зорчих хэсэг талд ачаа буулгах, ачих, тэр талын цонхоор биеэ болон бусад зүйл гаргахыг тээврийн хэрэгслээр зорчигчид хориглосон заалт нэмж тусгалаа;

д/ Автобусаар зорчигчийн аюулгүй байдлыг хамгаалах үүднээс "Хаалгыг жолоочийн суудлаас удирддаг бол гүйцэд зогсоогүй байхдаа хаалга нээхийг хориглоно" гэсэн заалт нэмж тусгалаа;

е/ Зорчигчийг суурин газрын доторх чиглэлийн тээврийн хэрэгслээр тээвэрлэхээс бусад тохиолдолд зогсоогоор нь тээвэрлэхийг хориглосон заалт тусгалаа;

ё/ Зам тээврийн ослын үед зорчигчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, бэртэж, гэмтэх эрсдэлээс сэргийлэх үүднээс хот хоорондын болон аялал, жуулчлалаар явах автобусан доторх суудал бүрийг хамгаалах бүсээр тоногдсон байх шаардлагыг нэмж тусгалаа;

з/ Тээврийн хэрэгслээр зорчигчийн аюулгүй байдлыг хангах, зорчигчоос шалтгаалан аюул, осол гарахаас сэргийлэх үүднээс трактор болон өөрөө явдаг машин, механизмд зорчигч тээвэрлэх, мөн жолоочийн өвөр дээр, эсвэл суудлын ба ачааны автомашины жолоочийн бүхээгт зорчигчийн өвөр дээр хүн тээвэрлэх, өөрийн үйлдлийг хянах чадваргүй (согтуурсан, мансуурсан гэх мэт) хүнийг урд суудалд, эсвэл жолоочоос өөр харгалзаж хамгаалах хүнгүйгээр тээвэрлэх зэргийг жолоочид хориглолоо.

7. Замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг багасгаж, хөдөлгөөний эрчмийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэмэлт, өөрчлөлтүүд:

а/ Замын хөдөлгөөний тухай болон Замын дохио, тэмдгийн тухай Венийн конвенцуудад хамгийн сүүлд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан унадаг дугуйн хэрэглээг дэмжих үүднээс унадаг дугуй, мопедоор замын хөдөлгөөнд хөнгөн шуурхай, аюул, бэрхшээлгүй оролцох нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн эрх зүйн шинэ зохицуулалтыг төсөлд тусгалаа;

б/ Замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг бууруулах, автомашины хэрэглээг багасгахад чухал үр нөлөөтэй арга хэмжээнүүдийн тоонд нийтийн тээврийн үйлчилгээг хөнгөн шуурхай, оновчтой болгож, энэ үйлчилгээг сонгох иргэдийн сонирхлыг нэмэгдүүлэх явдал бөгөөд энэ зорилгоор сүүлийн жилүүдэд нийтийн тээврийг тусгай (баруун гар талын) эгнээгээр явуулах арга хэмжээг хэрэгжүүлж байгаа билээ. Гэвч замын хөдөлгөөний дүрэмд энэ талаар зохицуулсан заалт тусгагдаагүй тул тус арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа юм. Үүнийг шийдвэрлэх үүднээс төсөлд холбогдох зохицуулалтыг тусгалаа;

в/ Чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр бусад тээврийн хэрэгсэл байрлан явахыг хориглосон заалтыг суудлын таксид хамаарахгүй байхаар тусгасан нь таксигаар үйлчлүүлэх иргэдийн сонирхлыг нэмэгдүүлэх хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслийн тоог бууруулахад ач холбогдолтой гэж үзлээ;

г/ Гэрлэн дохионы зохицуулгатай зарим уулзвар дээр хөдөлгөөний эрчмийг харгалзан тооцож, баруун гар тийш эргэх тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнийг байнгын нээлттэйгээр зохион байгуулах нь тухайн уулзварын хөдөлгөөний нягтралыг багасгаж, эрчмийг сайжруулахад үр дүнтэй арга хэмжээ болдог бөгөөд үүнийг эрх зүйн зохицуулгатай болгох үүднээс холбогдох заалтыг төсөлд тусгасан;

д/ Зарим жолооч нар гэрлэн дохионы зохицуулгатай уулзварын өмнө нэмэгдэл гэрэл дохионы сум заасан чигийн дагуу эргэх захын эгнээг эзэлж уг чигт эргэхгүйгээр дараагийн дохиог хүлээн зогсож бусдын хөдөлгөөнийг саатуулж улмаар уулзварын эрчмийг бууруулан зохиомол нягтрал үүсгэдэг явдлыг таслан зогсоох үүднээс холбогдох заалтыг тусгалаа;

е/ Зорчих хэсэг дээр эгнээний тоо, хажуугийн зайг баримтлахгүйгээр давхарлан явж хөдөлгөөнийг саатуулах, улмаар хоорондоо мөргөлдөж шүргэлцэх зэргээр осол гаргадаг явдлыг таслан зогсоох үүднээс “Эгнээний хилийг тэмдэглэсэн зорчих хэсэг дээр жолооч тээврийн хэрэгслээрээ тухайн эгнээг голлож явна” гэсэн заалт тусгалаа;

ё/ Нарийн замд хурд багатай буюу овор ихтэй тээврийн хэрэгслээс шалтгаалж хөдөлгөөний нягтрал нэмэгдэх, эрчим буурахаас сэргийлсэн зохицуулалтыг мөн тусгалаа;

ж/ Нийтийн тээврийн автобус, троллейбусууд буудлын талбай руугаа бүрэн гүйцэд орж зогсохгүй, зарим тохиолдолд давхарлан зогсдогоос шалтгаалан хөдөлгөөний аюулгүй байдал алдагдан, замын түгжрэл үүсэж байгааг харгалзан холбогдох зохицуулалтыг тусгалаа;

з/ Одоо мөрдөж буй дүрмийн 12.2-ыг шинэчлэн найруулж, төслийн 15.2-т “Уулзварыг бүрэн гүйцэд нэвтрэн гарах боломжийг хязгаарласан түгжрэл, саатал бий болсон үед жолооч (уулзвар нэвтрэх давуу эрхтэй буюу зөвшөөрсөн гэрэл дохио асаж байгаа эсэхээс үл хамааран) уулзвар руу орохыг хориглоно” гэж зааснаар уулзвар дээр үүсэх түгжрэл саатлыг багасгахад чухал ач холбогдолтой гэж үзлээ.

Замын хөдөлгөөний дүрмийн төслийн шинэчилсэн найруулгыг баталснаар Улсын төсвөөс нэмэлт санхүүжилт шаардлагагүй болно.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ